ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

# ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ



УЛААНБААТАР
2023




Шинжлэх Ухааны Академийн
Хэл зохиолын хүрээлэн

# ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛ-2023
# ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Урилга, хөтөлбөр, хураангуй


Улаанбаатар хот
2023

**УРИЛГА**

Эрхэм хүндэт..... таныг

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс уламжлал болгон зохион байгуулдаг
**“ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛ”**
эрдэм шинжилгээний хуралд хүрэлцэн ирэхийг урья.

**Хэзээ**: 2023 оны 11 сарын 28-ны Мягмар гараг, 08:30 цагт
**Хаана**: Монголын Уран Зургийн Галерей,
II давхар, Хурлын танхим.




Сүхбаатарын талбай, Соёлын төв өргөөний Б корпус

08:30-09:00 Бүртгэл

**ХУРЛЫН НЭЭЛТ**

09:00-09:10 Урлагийн мэндчилгээ: “Хатад” хамтлаг
09:10-09:20 Нээлтийн үг:
**Ж.Бат-Ирээдүй** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал

**ХЭЛ ШИНЖЛЭЛ**

**Хурлын чиглүүлэгч:**
**Д.Боролзой** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн
**Хурлын нарийн бичгийн дарга:**
**М.Очирцэнд** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

09:30-09:40 **М.Саруул-Эрдэнэ** (АНУ-ын Конгрессын номын сан) *Николас Поппе, Франсис Кливез нарын захидал харилцаанаас монгол хэл зохиол судлалын түүхийг мөшгөхүй*

09:40-09:50 **Л.Цэрэнчимэд** (МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль) *Буриад аялгууны “хүхэ” хэмээх үг бүхий хэлц үгийн утга, соёлын онцлог*

09:50-10:00 **Ж.Ганбаатар** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль) *Монгол хэлний зарим мөхсөн дагаврын тухай*

10:00-10:10 **Г.Бямбацэрэн** (МУБИС-ийн Багшийн сургууль) *Багш бэлтгэдэг сургуулийн хөтөлбөр дэх төрөлх хэлний судлагдахууны агуулгын өөрчлөлт*

10:10-10:20 **Б.Золжаргал (**ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн) *Байгалийн ухааны нэр томьёо бүтэх онцлог (Адилтгалын аргын жишээгээр*)

10:20-10:30 **М.Энхжаргал** (МУБИС-ийн Багшийн сургууль) *Монгол хэлний үгийн бүтцээс хасагдсан дэд авиалбарт зарим үгийн бүтэц, утга, үүрэг*

10:30-10:40 **Б.Пүрэвсүрэн** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль) *Монгол хэлний ялгах ёс нэрийн хэлцэд илрэх тухай*

10:40-10:50 **Б.Дэлгэрмаа** (ШУТИС-ийн Гадаад хэлний сургууль) *Эрчим хүчний салбарын монгол нэр томьёо бүрэлдсэн нь*

10:50-11:00 **О.Нандин-Эрдэнэ** (ШУТИС-ийн "Эрдэнэт" цогцолбор дээд сургууль) *Монгол хэлний шар өнгө заасан нэрийг авалцуулан холбох аргаар судлах нь*

**11:00-11:20 Хэлэлцүүлэг**

**11:20-12:00 Номын нээлт**

- Төвөд хэлт сургаалын зохиолын бичвэр зүйн судалгаа I. Уб., 2023.
- Судар бичгийн хүрээлэнгийн мэргэд. Уб., 2023.

## АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ

**Хурлын чиглүүлэгч:**
**Б.Дайриймаа** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн
**Хурлын нарийн бичгийн дарга:**
**Г.Батмөнх** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

12:00-12:10 **М.Уганбаяр** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль) *Монгол тува бөөгнөл үлгэрүүд*

12:10-12:20 **О.Болор-Эрдэнэ (**ӨМБИС-ийн Монгол судлалын дээд сургууль**)** *Оньсогын шүлэглэг шинж ба шүлгийн оньсоголог шинж*

12:20-12:30 **В.Янжиндулам** (МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургууль)
**Л.Гүндсамбуу** (МУИС-ийн МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*“Жангар” туульдахь уриа дуудлага, сахиусаар хүчийг илтгэх үзэл ухамсар*

12:30-12:40 **Хосбаяр (**МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль) *“Бодь галав хаан” туульдахь мангасыг галаар дарах өгүүлэмж, түүний утга, бэлгэдэл*

12:40-12:50 **Н.Бадамцэцэг** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль) *Шинжаануы Ховог сайрын уртын дуун дахь морины зүс заасан үгсийг бэлгэдэл зүйн талаас авч үзэх нь (Шинжаануы Ховог сайрын ардын дуучин Н.Намжавын дуулсан дууны жишээгээр)*

12:50-13:00 **Сэцэнтунгалаг (**МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль**)** *“Эрхий мэргэн” үлгэрийн мотивын судалгаа*

13:00-13:10 **Тогтох (**СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль**)** *Үзэмчин уртын дууны яруу найраг дахь соёлын утгыг танихуйн үүднээс авч үзэх нь*

**13:10-13:30 Хэлэлцүүлэг**

**13:30-14:00 Үдийн хоол**

## УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

**Хурлын чиглүүлэгч:**

**Д.Болормаа** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

**Хурлын нарийн бичгийн дарга:**

**Ж.Уганбаатар** ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

14:00-14:10 **Г.Билгүүдэй** (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн) *Ц.Дамдинсүрэнгийн эрдмийн ажлын өв - Монгол Улсад Равжаа судлалын эхийг тавьсан нь*

14:10-14:20 **Б.Хишигсүх, Э.Сурнаа** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль) *Юань гүрний жүжгийн зохиолын өрнө дахин дахь судалгаа*

14:20-14:30 **Владимир Куликов (**Беларусийн Улсын Технологийн Их Сургууль**)** *Беларусь бичвэртэй зэрэгцүүлсэн "Монголын нууц товчоо" номын үндсэн үүрэг*

14:30-14:40 **Ш.Баттөр, Ө.Саранчимэг** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль) *Өвөр Монголын орчин цагийн тууж, өгүүллэгийн туурвил зүйн зарим асуудал*

14:40-14:50 **Д.Мөнхнаран** *Дамдинсүрэнгийн Урианхайн яруу найргийн бүтээлд туссан улс төр, экологийн үзэл санаа*

**14:50-15:00** ***Цайны завсарлага***

15:00-15:10 **Х.Түмэнбаяр** (Соёлын Өвийн Үндэсний Төв) *“Их монголын орны эртний түүхийн тэмдэглэл шастирын өнцгийн чимэгт монгол үсгээс төвөд хэлэнд орчуулан зохиосон оршив” хэмээх түүхэн сурвалжийн тухай*

15:10-15:20 **Д.Мөнх-Отгон** (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн) “*Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу” зохиолын анхны хэвлэлүүд*

15:20-15:30 **Анхилам (**ӨМБИС-ийн Монгол судлалын дээд сургууль**)** *Цахим сүлжээ дэх яруу найргийн уламжлан дамжих үйл явцыг шинжлэх нь*

15:30-15:40 **Урьхан (**ӨМБИС-ийн Монгол судлалын дээд сургууль) *Өвөр Монголын бие махбодын гоо зүйн судалгааны тойм (Өвөр Монголын одоо үеийн уран зохиолын жишээгээр)*

15:40-15:50 **Хэлэлцүүлэг**

15:50-16:00 **Хурлын хаалт:**
**О.Шинэбаяр** (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ЭНБД)

## ХАНЫН ИЛТГЭЛ

**Т.Батбямба** (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн) *Стандартчилсан нэр томьёоны бүтцэд хийсэн тоон шинжилгээ*

**Э.Эрдэнэзуу** (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн)

**Б.Ганчимэг** (Чингис хааны өв, соёлын хүрээлэн) *Махгалын гэрэлт хөшөөний манж бичээсийн үгийн сан, үсэг зүйн онцлогоос*

**Амар** **(**МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль**)** *Монгол Улсын “Үнэн”, ӨМӨЗО-ы “Өвөр Монголын өдрийн сонин” (1950-1960 он) сонины хэл найруулгад хийсэн ажиглалт*

**Б.Өргөнбуян** (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль) *“Dede Korkut Kitabi” хэмээх сурвалжийн тухай*

**Илтгэлийн хураангуй**


| № | Илтгэгч | Хуудасны дугаар |
|---|---|---|
| 1. | М.Саруул-Эрдэнэ | 10 |
| 2. | Л.Цэрэнчимэд | 11 |
| 3. | Ж.Ганбаатар | 15 |
| 4. | Г..Бямбацэрэн | 16 |
| 5. | Б.Золжаргал | 18 |
| 6. | М.Энхжаргал | 19 |
| 7. | Б.Пүрэвсүрэн | 23 |
| 8. | Б.Дэлгэрмаа | 26 |
| 9. | О.Нандин-Эрдэнэ | 28 |
| 10. | М.Ууганбаяр | 30 |
| 11. | О.Болор-Эрдэнэ | 31 |
| 12. | В.Янжиндулам, Л.Гүндсамбуу | 32 |
| 13. | Хосбаяр | 33 |
| 14. | Н.Бадамцэцэг | 34 |
| 15. | Сэцэнтунгалаг | 36 |
| 16. | Тогтох | 39 |
| 17. | Г.Билгүүдэй | 40 |
| 18. | Б.Хишигсүх, Э.Сурнаа | 41 |
| 19. | Владимир Куликов | 42 |
| 20. | Ш.Баттөр, Ө.Саранчимэг | 43 |
| 21. | Д.Мөнхнаран | 44 |
| 22. | Х.Түмэнбаяр | 45 |
| 23. | Д.Мөнх-Отгон | 46 |
| 24. | Анхилам | 47 |
| 25. | Урьхан | 48 |
| 26. | Т.Батбямба | 49 |
| 27. | Э.Эрдэнэзуу, Б.Ганчимэг | 50 |
| 28. | Амар | 52 |
| 29. | Б.Өргөнбуян | 53 |

# НИКОЛАС ПОППЕ, ФРАНСИС КЛИВЕЗ НАРЫН ЗАХИДАЛ ХАРИЛЦААНААС МОНГОЛ ХЭЛ ЗОХИОЛ СУДЛАЛЫН ТҮҮХИЙГ МӨШГӨХҮЙ

*Доктор (Ph.D) Мягмарын Саруул-Эрдэнэ*
*(АНУ-ын Конгрессын номын сан)*

Бидэнд олдоод буй баримтаар бол монгол судлаач Николас Поппе Франсис Вүүдмэн Кливез хоёр лавтайяа 1948 оны дөрөвдүгээр сараас эхлээд 1959 оны есдүгээр сарыг хүртэл захидлаар харилцжээ. Энэ үед Кливез нь Харвардын их сургуульд, Поппе нь Вашингтоны их сургуульд монгол судлалыг үүтгэн, хөгжүүлж байсан юм. Хэдийгээр эдгээр захидал нь хувь хүн хоорондын харилцаа боловч агуулгыг нь хянан үзвээс:

- Монгол хэл бичгийн олон сонирхолтой дурсгалыг хэлэлцэн ярьж буй нь эх судлалын,
- Олон монгол, нангиад, түрэг үгийн гарлын талаар саналаа солилцсон нь үгийн гарал судлалын,
- Үг зүйн тодорхой хэлбэрүүдийг ухан шинжилсэн нь монгол хэл зүйн,
- Монголд болон монгол судлалын ертөнцөд болж үйл явдлын талаар үзлээ илэрхийлсэн нь монгол судлалын түүхийн,
- Тодорхой монголч эрдэмтдийн талаар урьд өмнө хэвлэгдэж байгаагүй баримтуудыг сөхсөн нь намтар судлалын түвшинд тус тус эх сурвалж болохуйц баримт мөн болох нь тодорхой байв. АНУ-ын хэд хэдэн номын сан, хувь хүний цуглуулгаас олдсон эдгээр захидал харилцаан дахь онц чухал мэдээллийг илтгэгч танилцуулах юм.

# БУРИАД АЯЛГУУНЫ “ХҮХЭ” ХЭМЭЭХ ҮГ БҮХИЙ ЗАРИМ ХЭЛЦ ҮГИЙН УТГА, СОЁЛЫН ОНЦЛОГ

*Доктор (Ph.D) Лувсанцэрэнгийн Цэрэнчимэд*
*(МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль)*

Монгол хэлний бүрэлдэхүүн буриад аялгууны “хүхэ” гэдэг үг орсон хэлц үгсийн утга болон соёлын онцлогийг угсаатны танин мэдэхүй, амьдралын хэв маяг, зан заншлын үүднээс тодруулж тайлбарлав. Судалгаанд өгүүлсэн хэлц үгийн зарим нь буриад аялгууны толь бичигт тэмдэглэгдээгүй зөвхөн аман ярианд хэрэглэгдэж байгаагаараа онцлог юм. Өгүүлэлд тайлбарласан хэлц үгсийн тодорхой хэсэгт нь дундад үеийн монгол хэлний “хөх” хэмээх үгийн өнгө заасан үндсэн утга хадгалагдсан байна. Зарим хэлц үгээр урт, богино хугацаанд үргэлжилсэн цагийн утга илэрч байгаа нь “мөнх хөх тэнгэр” гэсэн тогтвортой хэллэгийн хам утгатай холбоотой ажээ. Буриад аялгууны “хүхэ” хэмээх үг бүхий хэлц үгсийн утга, соёлын өөр нэг онцлог нь хүний гадаад шинж, зан байдал, амьдралын хэв маягийг өгүүлсэн тохиолдолд өгүүлэгчийн үнэлэмж, мэдрэмжийг илэрхийлсэн өвөрмөц жишиг хэмжүүр болсонд оршино.

Хүний хэлний тогтвортой нэгж болоод угсаатны олон янз байдлыг, соёлын асуудал, тэдгээрийн утга, хэл сэтгэлгээний онцлог зэрэг олон талт асуудлыг анх холбоо хамааралд нь судалсан Эдвард Тайлор, Франц Баос, Эдвард Сапир, Бенжамин Воорф (Уорф), В.А.Маслова, В.Н.Телия нарын бүтээлийг онолын үндэс болгох нь түгээмэл.

Энд олон хэлний бус олон өөр соёлын харилцаа холбоо бус харин монгол хэлний нэг аялгуу, монгол угсаатны нэг болох буриад-монголчуудын өдөр тутмын аман ярианд хэлэлцдэг хэдэн хэлц үгийн бүрэлдэхүүн дэх “хөх” хэмээх өнгө заасан үгийн утга, соёлын зарим онцлогийг тодруулахыг зорилоо.

Монгол хэлний “хөх” хэмээх үгийг: “I. номин чулууны адил үндсэн өнгүүдийн нэг; II. амьтны үр зулзагаа тэжээх сүүний булчирхай: хөх дэлэн хорш; III. Зэрлэг гахайн зулзага;

IY. Үхрийн омруу” гэсэн үндсэн дөрвөн утгатай хэмээжээ (Я.Цэвэл, 1966: 718). Эдгээрээс нэгдүгээр буюу номин чулууны адил үндсэн өнгүүдийн нэг гэсэн утга нь буриад хэл, аялгууны хэлц үгийн бүрэлдэхүүнд ямар утга, өвөрмөц онцлогтой байгаад түлхүү анхаарав.

Дундад үеийн монгол хэлний үгийн сангийн онцлогийг тусгасан Мукаддимат Ал-Адаб тольд: “хөх” хэмээх үгийн утгыг: “köke - kök- небо; kökürkireki ~ donqatqu; köke bora morin; kök ebesüni γaǰar; kök ebesün hürün гэх зэрэг баримтаар тайлбарлажээ (Н. Поппе, 1938:220). Эндээс “хөх” хэмээх үгээр “тэнгэр”-ийг нэрлэхийн хамт өнгө зүс заасан утгаар хэрэглэж байсныг харж болно. Тэгвэл “тэнгэр”-ийн утгыг хэрхэн тайлбарласныг харвал: “tengri čakimui, tengri donγ [utba]; kümün tengri отшельник (даяанч)” (Н. Поппе, 1938, p448).

Тус илтгэлийн агуулгыг үндсэн гурван хэсгээр авч үзэж байна. Үүнд:

1. Буриад аялгууны “хүхэ” хэмээх үг бүхий хэлц үгийн бүрэлдэхүүн дэх өнгөний бэлгэдэл ба байгалийн юм, үзэгдлийг төлөөлөн нэрлэсэн нь

• “Хүхээ холо дайдада ~ Алтай холо дайдада; Хан Хүхэһээ~(өө) ерэһэн

2. Буриад аялгууны “хүхэ” хэмээх үг бүхий хэлц үгсээр цаг хугацааны утга илэрсэн нь

• Хүхэ бороо- зүс бороо, хүхэрэжэ орохо- бороо хэд хоногоор үргэлжлэн орох гэсэн хэлц үгийн бүрэлдэхүүн дэх “хөх, хөхрөх” нь мөнх хөх тэнгэрийн цаглашгүй шинжээс улбаатай харьцангуй үргэлжлэх цагийн утга зааж байна. Ийм утгыг монголчуудын мал аж ахуйтай холбоотой таван хошуу малын ялгадас, өтөг бууцны хамаат хэллэгээс ч харж болох юм. Жишээ нь:

• хүхэ бууса~ хөх бууц – хонь, ямааны хоргол шээс шивтэр, малын хөлд дагтаршсаныг,

• хүхэ тонтогоол~хөх хомоол – олон жилийн өнжмөл,

• хүхэ аргал~ хөх аргал – жил өнжсөнийг хэлнэ (Д.Баттогтох, 2022: 591-593) Эдгээрт өнгө болоод цаг хугацааны утгын аль аль нь илэрчээ. Энэ нь хөдөө гадаа нар салхинд удаан

болсон аливаа эд зүйл, юмс өнгө алдан хувирдаг тэрхүү шинжийг таньсан туршлагаа хэлний нэгжээр илэрхийлсэн нь хэвшин тогтсон хэрэг. Энэ мэт холбоотой бусад хэлц үгийн утга соёлын онцлогийг авч үзнэ.

3. Буриад аялгууны “хүхэ” хэмээх үг бүхий хэлц үгсээр өгүүлэгчийн үнэлэмж, жишиг хэмжүүрийн утга илэрсэн нь

Буриад аялгуунд өвөрмөц ба хэвшмэл хэлцийн үндсэн бүрэлдүүлэгчийн нэг болсон “хүхэ” гэх үгийг өнгө заасан утгаас гадна шилжсэн утгаар хэрэглэнэ. Тодруулбал, өгүүлэгчийн мэдрэмж, үнэлэмжийг илэрхийлж, жишиг хэмжүүрийн шинжтэй болсон дараах хэлц үгийг дурдаж болно. Үүнд:

- Хүхэ түриһэн ~ (дурһан) болотороо наадаха~ зайха – гадуур хэсэх, тоглох
- Хүхэ дэлюүн болотороо даараха – маш их даарах
- Хүхэ сагаан болохо – царай нь цайх
- Хүхэ модон болотороо энеэхэ – маш чанга, удаан инээх
- Хүхэ модон болотороо арсалдаха – ядартлаа тэмцэлдэх
- Хүхэ гал оролдохо – хичээл зүтгэл гаргах, зорьсноо биелүүлэх
- Хүхэ нэтэ – зөрүүд, төлөвлөсөн ажлаа дуусгах
- Хүхэ хүлеэлгэн – удаан хүлээх
- Хүхэ ханяадан – хүнд ханиад
- Хүхэрэһэн амитан ~ архиншан- архины хамааралтай хүн
- Хүхэ нюуртай - нүүрэмгий, алив асуудлын түрүүнд явдаг гэх мэт.

Судалгаанд тайлбарласан хэлц үгүүдэд байгалийн юм, үзэгдэл болоод хүний гадаад төрх, сэтгэл хөдлөл, хандлагыг үнэлсэн, жишиг хэмжүүрийн утга түлхүү илэрсэн нь хүний танин мэдэхүйн үндсэн зарчим, туршлагатай холбоотой юм. Тодруулбал, “Человек-мера всех вещей,” буюу хүн бол бүх зүйлийн хэмжүүр (Протагор МЭӨ 450), “Вещь-мера всех людей” юмс бол хүмүүсийн хэмжүүр (В.Н.Топоров, 1995:17) гэсэн зарчмаар ойлгож болно. Адилтган үзэж буй ойлголтдоо “хүн хийгээд хүрээлэн буй юмс”-ын алийг нь чухалчлах, эс

чухалчлахаас шалтгаалж, угсаатны соёл, зан үйл, бэлгэдлийн өвөрмөц ба нийтлэг шинж тодордог онцлогтой байна.

Дундад үеийн монгол хэлний зарим баримтад байгаа “мөнх хөх тэнгэр” хэмээх цаг хугацааны үргэлжлэх, тогтвортой байдал ба оюун санааны бэлгэдэл болсон хийсвэр утга хүхэ бороо, хүхэрэжэ орохо, хүхэ гал оролдохо, хүхэ нэтэ хүн, хүхэрэһэн амитан гэх мэт хэлц үгэнд (хөх хэмээх үг орсон хэлцээр илэрч буй цаг хугацааны утга, хэмжүүр) хадгалагджээ.

# МОНГОЛ ХЭЛНИЙ ЗАРИМ МӨХСӨН ДАГАВРЫН ТУХАЙ

*Доктор (Ph.D) Жавзандуламын Ганбаатар*
*(МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*

Монгол хэлний үгийн гарлыг судлан тогтооход идэвхтэй болоод идэвхгүй язгуурыг түүхэн үүднээс задлан тайлбарлах нь чухал юм. Ш.Лувсанвандан язгуурыг анхдагч, үүсмэл гэж хоёр ангилаад “анхдагч язгуур нь цаашид үл задрах цэвэр язгуур байдаг бол үүсмэл язгуур нь идэвхгүй анхдагч язгуур дээр мөн идэвхгүй болсон нэг буюу хэдэн дагавар залгаж бүтсэн байна. Жишээлбэл, цагаан гэсэн үгэнд тохиолдох ца- язгуур нь идэвхгүй анхдагч язгуур, -га нь идэвхгүй дагавар, энэ хоёр нийлж цага- гэсэн үүсмэл язгуур болно” (1963/2010: 76) гэжээ. Тэр бээр “...орчин цагийнхаа хэлэнд бодит утгаа алдаж, үг бүтээх, үндэс үүсгэхэд язгуур болж чадахгүй, ганцхан түүхийн үүднээс задлан үзвэл сая мэдэгдэх тийм язгуурыг мөхсөн язгуур гэнэ. ...Хэрэв ямар нэгэн үгийн язгуур мөхвөл түүний дагавар ч нэгэн адил мөхнө” (1964 /2019: 40-41) гэжээ. Судлаачид орчин цагийн монгол хэлний үг бүтээх дагаврын утга, үүрэг, байрыг нь тодорхойлсоор ирсэн боловч мөхсөн дагаврын талаарх судалгаа гараагүй байна.

Б.Ринчен (1966), Ц.Өлзийхутаг (1972) нар дагаврыг утгаар нь идэвхтэй, идэвхгүй гэж ангилаад “идэвхгүй дагавар монгол хэлэнд олон бөгөөд ялангуяа дүрслэх үгэнд үгийн эцэст байрлахаа больж ямагт үгийн дунд байх болжээ” хэмээгээд сарс-, барс-, сагс- -ын бүтэц дэх -с дагавар, сарлагар, сарамгар, сарвагар зэрэгт буй -л, -м, -в гэх мэт (1972: 108-111) дагаврыг идэвхгүй дагаварт багтана гэж үзжээ. Эдгээр угтаа нь утга, үүргээ алдаж язгуурын бүтцэд шингэсэн дагавар юм.

# БАГШ БЭЛТГЭДЭГ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨР ДЭХ ТӨРӨЛХ ХЭЛНИЙ СУДЛАГДАХУУНЫ АГУУЛГЫН ӨӨРЧЛӨЛТ

*Доктор (Ph.D) Ганжуурын Бямбацэрэн*
*(МУБИС-ийн Багшийн сургууль)*

Төрөлх хэлний боловсролын агуулгыг үгийн утгын код тайлах буюу унших чадвараар (Ari, 2017) хэлний нэгжүүдийн утга, бүтэц, хувиргал, соёлын ай дахь мэдлэг, чадвар, хэрэглээгээр (Grabe, 2009; Базаррагчаа, 2005), хэл шинжлэлийн ухааны онол, үзэл баримтлал, судлагдахууны хүрээгээр, тухайн шинжлэх ухааны судалгааны асуудлуудаар тодорхойлж ирсэн байна.

Боловсролын ирээдүйн чиг хандлагыг тодорхойлохдоо (Боловсролын ирээдүйг бүтээх нь, ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь, Schools of the Future Defining New Models of Education for the Fourth industral Revolution) боловсрол, суралцахуйн хүрээнд үүссэн уламжлалт ойлголтоо өөрчлөхийг заахын зэрэгцээ боловсролын үнэлгээний шалгуур болгож, математик - байгалийн ухаан, унших чадварт (PISA) суурилж байна. Өнөөдөр хэлний боловсролын агуулгын хүрээг дахин эргэн харж, сургалтын робот гарч, суралцахуйн 3 парадигм гарч байгаатай холбон өөрчлөх хэрэгцээ гарч байна.

Ирээдүйн иргэдэд боловсрол эзэмших эрхийг хангаж баталгаажуулахдаа ямар ур чадвар шаардлагатайг тодорхойлж, тэдэнд зориулсан боловсролын үзэл баримтлалыг боловсруулах, ямар тогтолцоог бүрдүүлэх, ямар хөтөлбөр байх гэдгээс ирээдүйн иргэний нийтлэг дүр төрхийг тодорхойлохыг оролдож байна. Ирээдүйн нийгмийн иргэний эзэмшсэн байх мэдлэг, чадвар, үнэт зүйлийг тодорхойлсон байдалд мета анализ хийхэд дэлхийн иргэн байх, харилцааны чадвартай байх (дижитал болон нийгмийн харилцаа, дасан зохицох чадвартай байх, эх дэлхийгээ хайрладаг байх, бие махбод, танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, ёс суртахуун нэгдэж цогцолсон төлөвшсөн иргэн байх… гэх мэт) нийтлэг томьёоллууд байна. Харин

боловсролын үзэл баримтлалаа насан туршдаа суралцах, боловсролд тэгш хамрах, боловсролыг дижиталчлах үзэл санааг чухалчилсан байх. (Edgar Faure, UNESCO,1971; WEF, 2019)

Академик судлагдахуун нь мэргэжлийн сонголтоос хамаарч янз бүр байх ч бүх багш боловсролын хөтөлбөрт төрөлх хэлний судлагдахууныг 3-аас доошгүй кредит судлахаар зааж, уг агуулгын хүрээ эх бичвэрт суралцахуйд чиглэсэн байна. Харин зарим нэг хөтөлбөрт харилцаа хэмээн багц үүсгэж, төрөлх болон гадаад хэл, дижитал бичиг үсэг, кодочлол (ICT)-ыг оруулсан байна. Энэ бүхнээс үзэхэд шинэ зууны иргэний нэн чухал чадваруудын нэг харилцааны чадвар гэдэг төрөлх хэлээр хязгаарлагдахгүй, бичиг үсгийн боловсролоос эхлээд цахим талбар дахь харилцаа хүртэлх асуудал хэлний боловсролын шалгуур болж байгааг харгалзан хэлний сургалтад дахин дизайнчлал хийх хэрэгцээ гарч байна.

Багшийн сургуулийн багш, бага боловсролын хөтөлбөрийн тавны нэг хувь нь төрөлх хэлний боловсролын агуулга байдаг бөгөөд түүний тал нь арга зүйд чиглэсэн байдаг. Уг багц хангалттай ч уламжлалт хичээлийн агуулга, арга зүйд суурилсан судалгаа хийхэд эрс тэс өөрчлөгдөх шаардлага байгаа харуулж байна. Хот хөдөөгийн 401 багшаас судалгаа авахад 74% нь хэрэгцээ хангаж чадахгүй байгаа, орж байгаа сургалтын хөтөлбөр дэх 27 хичээлээр эрэмбэ үүсгэхэд 21-т эрэмбэлэгдэж байгаа зэргээс үндэслэн зарим нэг хичээлийг нэршлийг өөрчлөх агуулгыг дахин тодорхойлох, сургалтын үйлийг шинээр загварчлах, хөгжүүлэлт хийх болж байгаа билээ.

# БАЙГАЛИЙН УХААНЫ НЭР ТОМЬЁО БҮТЭХ ОНЦЛОГ
## (Адилтгалын аргын жишээгээр)

*Доктор (Ph.D) Батбуяны Золжаргал*
*(ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн)*

Байгалийн ухааны нэр томьёонд танин мэдэхүйн онцлог туссан нь унаган байгалиа хайрлан хамгаалахын сацуу түүнтэй холбоотой нэрийг өвлөх, хэрэглэх, судлах үйл ажиллагаатай холбоотой уламжлал байсных билээ. Монголчууд нэр томьёо оноох, нэрлэх эртний уламжлалтай ард түмэн. Ардын аман болон бичгийн дурсгалуудад уламжлалт нэр томьёо арвин байдаг хэдий ч бичигт тусгаж буулгах нь арай хожуу үед хамаардаг. Байгалийг таних арга, сэтгэхүйн онцлог нь ардын ухаанд уламжлагдсан байдлыг ажиглавал сонирхолтой. Хүний амьдралд хамгийн ойр байдаг ургамлын ургах, үржих цаг хугацаа, үйл явцыг мал амьтны өсөж үржихтэй адилтган нэрлэсэн үг хэллэг арвин байна. Энэ нь аман болон бичгийн хэлэнд уламжлагдан ирсэн байдаг. Жишээлбэл: соёо (всходы) гэх үг бий. Ургамлын дөнгөж цухуйж буй нахиа найлзуурыг “соёо” хэмээн нэрлэдэг. Соёо хэмээх үгийн үндсэн утга нь үүдэн шүд, араа хоёрын хооронд байх ганц ёзоортой шовх шүдийг хэлнэ. Харин энэ үндсэн утгаас утга шилжиж, ургамлын дөнгөж цухуйж буй нахиа найлзуурыг хэлэх болж, буудайн соёо (буудайн найлзуур), ногооны соёо (ногооны үзүүр найлзуур), хулс модны соёо (хулс модны нахиа найлзуур), соёо гарах (өвс ургамлын нахиалах, ургаж эхлэх) зэргээр баяжжээ. Ургамал модны дөнгөж урган гарч буй байдал нь соёо шүд цухуйн харагдах байдалтай төстэй тул ийн адилтган нэрлэсэн нь сонирхолтой. Үүнчлэн амьтны соёо шүд ургахтай ижилсгэн ургамлын сүелэх үеийг “соёолох” хэмээн нэрлэдэг байна. Тухайлбал: үндэс соёолох, үр соёолох гэж бий. Нэр томьёо оноох, зохиоход адилтгалын аргыг хэрхэн хэрэглэсэн талаарх судалгааг танилцуулна.

# МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГИЙН БҮТЦЭЭС ХАСАГДСАН ДЭД АВИАЛБАРТ ЗАРИМ ҮГИЙН БҮТЭЦ, УТГА, ҮҮРЭГ

*Доктор (Ph.D) Мэндсайханы Энхжаргал*
*(МУБИС-ийн Багшийн сургууль)*

Өгүүлэгч өөрийн санаа бодлыг илүү ойлгомжтой, тодорхой илэрхийлэхийн тулд үгийн аль нэг үе, аль нэг авиалбарыг өргөлттэй хэлэх, дууны өнгөөр ялгах, уртаар дуудах, үе, авиалбарыг нэмэх, эсвэл урт эгшгийг богиноор дуудах, үе, авиалбарыг хасах зэргээр авианы бүрэлдэхүүнийг зориудаар өөрчлөн үгийн хувилбар үүсгэснийг дэд авиалбар (ор. субфонема, анг. sub phoneme) гэнэ. Дэд авиалбар нь зарим талаар найруулгын үүрэгтэй, үгийн дуудлагын хувилбар болохоос биш, үгийн утгыг өөрчилдөггүй. Монгол хэлэнд дэд авиалбар үүсэх нь үгийн бүтцээс хасагдаж, мөн үгийн бүтцэд нэмэгдэж үүсэх тохиолдол байна.

Дэд авиалбараар үүссэн үгс нь тухайн үгийн авиалбарын бүтцийг өөрчилж байгаа ч үгийн сангийн түвшинд утга ялгахгүй байгаа бөгөөд үүнийг эрдэмтэд тал бүрээс нь судалсан байдаг. Үүнд: “Үгийн болон бүтээврийн хувилбар бүтээдэг хувилбарыг эрдэмтэд сайн дурын бүтээвэр, авиа (факультативный вариант) (Трубецкой 1960: 53-54); “дуудлагын бүрэн стиль” гэж нэрлээд “бүрэн стильд үгийн авианы бүрэлдэхүүнүүд нь зориудаар хийсвэр авианууд хэлсэн байдаг” (Щерба); “Утга үл ялгах авиалбар”-ыг дэд авиалбар (ор. субфонема, анг. subphoneme, infraphoneme) (Ахманова 1966а: 460, 462); шугамын биш авиалбар, өөрөөр хэлбэл, өргөлт, хөг, аялганаас бүтсэн бүтээвэр гэж байна (Нямсүрэн 1974: 58); эгшиглэх өргөлт (Цолоо 1976:154); онцолсон авиа (Базаррагчаа, Идэрбаяр 1993:61-68); нэмэлт залгавар “suprafixes” (Матюс 1989:116); “үгийн сан ба утга ялгах өргөлт” (Өнөрбаян 2004:84); дэд-авиалбарын залгавар (sub-phonemic affix) (Крюгер 2005:308); “хувилбар дуудлага (variation pronunciation)

(Самбуудорж 2011: 5); дэд өргөлт (Базаррагчаа 2017: 143) гэж нэрлэжээ.

Хэлний яруулаар авиалбар нэмэгддэг байхад хэлний хэмнэлтийн зарчмаар хасагдах тохиолдол байна. Энэ нь хэлний авианы өөрчлөлттэй холбоотой үзэгдэл бөгөөд ярианы урсгалд авиа утга ялгах үүрэггүй болсон, эсвэл нэг авианы үүргийг нөгөө авиа хавсран гүйцэтгэх үед гээгддэг байна. Үүнийг хэл шинжлэлд авиа сулрах ёс, авиа сугарах ёс, авиа хасагдах, авиа товчлогдох, авиа гээгдэх, авианы унал гэх мэтээр (Ринчен 2015: 196; Лувсанвандан 1961: 83; Баяансан, Одонтөр 1995: 22; Чоймаа 1997: 161-162; Санжаа, Надмид 2008: 195; Шагдарсүрэн 2009: 73-86) нэрлэсээр ирсэн.

Ингэж үгийн бүтцэд авиа сэлгэх, авиа сугарах үзэгдэл монгол хэлэнд байгааг монголч эрдэмтэн Т.А.Бертагаев ажиглан энэ нь үгийн хувилбар үүсгэнэ гэж үзсэн байдаг. Тухайлбал: авиа сугарах үзэгдлийг үгийн эхэнд, үгийн дунд-төгсгөлөөс сугарах гэж хоёр ангилжээ. Үгийн эхэнд сугарсан оногд > ногд (монг.), сундуй > ундуй (монг.), өчүүхэн > цөөхөн (монг.), юроол > үреэл (бур.), hанжагар > унжагар (бур.), мүнөөхи > өнөөхи (бур.); үгийн дунд болон төгсгөлөөс сугарсан үгсэд үлдэхэ > үлэхэ (бур.), хаанашъе > хаанаш (бур.), бүгэжэ > бүгжэ (бур.), талбиу(н) > тавиу(н) (монг.), шалбайх > шалайх(монг.), зэрэмдэг > зэмдэг (монг.), нэжгээд > нэжээд (монг.), сүмбэр > сүмэр (монг.) (1969: 173-180). Авиа сулрах, гээгдэх зэрэг хэмнэл нь хүмүүсийн өөр хоорондоо харилцах явцад илүү тодорхой илэрдэг байна.

Мөн Ж.Баяансан, Ш.Одонтөр нарын хэл шинжлэлийн товч тайлбар тольд “Авиа жийрэглэх үзэгдлийн зэрэгцээ авианы унал (diaeresis) мөн явагддаг. Энэ нь тухайн үгийн бүтэц дэх VC авиа хэлэх урсгалаас хамаарч суларч гээгдэх үзэгдэл юм. Жишээ нь: эмнэлэг-emleg гэх мэт” (Баяансан, Одонтөр 1995: 22).

Судлаач Ш.Чоймаа монгол хэлний үг бүтэх аргыг үг зүйн ба үг зүйн бус арга хоёр ангилсан бөгөөд үг зүйн бус аргын нэг нь авиан зүйн арга гээд, авиан зүйн аргыг “1. эгшгийн сэлгэлт, 2. гийгүүлэгч сэлгэлт, 3. авиа товчлогдон үг бүтэх, 4. авиа, үе тонгорч үг бүтэх” хэмээн дөрөв ангилжээ. Үүний авиа

товчлогдон үг бүтэх аргад оногдох - ногдох, хонжих - хожих, хэлтлэх - элтлэх, хутгах -утгах, ханхлах - анхилах, дөндийх - өндийх, гэндэх - эндэх (Чоймаа 1997: 162) зэрэг жишээ дурдсан нь бидний судалгаатай холбогдож байна. Хэлний түүхэн хөгжлийн явцад бүтээврийн бүтцэд авиа нэмэгдэх, эсвэл хасагдах үзэгдлээс шалтгаалж бүтээврийн шинэ бүтэц үүсэх тохиолдол бий. Гэхдээ үгийн бүтцээс сугарч гээгдсэн үгийн утгыг өөрчлөхгүй байгааг дараах үгсийг бид дэд авиалбар сугарах үзэгдэлд хамруулан үзэж байна

Үгийн бүтцээс сугарсан болохыг дундад зууны үеийн монгол хэлний дурсгалын жишээ баримтаас харж болно. Тухайлбал: уйгар бичгийн дурсгалд ичгүүр (ičegü:ri) (n. Sub.II.:7b, IV:7a, V:3b, 4a, 7b, VIII:8a, 17b), хөвгүүн (köbegü:n) (n.Chang.13,17,25,36,37; Jig.13(2),21(2),31(2)…) (Төмөртогоо 2006: 450) хэмээн тохиолдож байна. Мөн айхавтар > айхтар, ичгэвтэр > ичивтэр хэмээн үгийн дундуур “-b”, “-m”, авиа үгийн дундуур сугарсан тухай Т.А.Бертагаев дурджээ (Бертагаев 1969: 179). Ийнхүү орчин цагийн монгол хэлэнд дэд авиалбараар үүссэн үгсийн хувилбар нь орчин цагт найруулгын ялгаа илэрхийлэх үүргээр хэрэглэгдэж байна.

Үгийн бүтцэд нэмэгдэж байгаа дэд авиалбарт нийт 100 үг байгаагаас 94 нь үгийн сангийн түвшинд утгын ялгаагүй, 8 үг нь бага зэрэг ялгаатай буюу салаа утгаараа тохирч байна. Тухайлбал, унхи гэсэн үг нь “1. хүний ухаан төхөө, 2. ухвар” гэсэн хоёр салаа хийсвэр утгатай байсан, харин унхиа болоход “1. арчаа, 2. ухвар” гэж “арчаа” гэсэн нэмэлт хийсвэр утга нэмэгдэж утга өргөссөн байна. Дэд авиалбарт холбогдох үгсийн тухай эрдэмтэн М.Базаррагчаа “Мөн нэрлэврийн хувилбар бий болоход оруулбар мэт зүйл, дэд өргөлт чухал үүрэг гүйцэтгэдэг байна” гээд “энэхэн - энүүхэн, эерүү - эевэрүү, цар - цараа, хэрэв - хэрвээ, алив - аливаа, хожих - хонжих, урждар - уржигдар, жихүүн - жихрүүн, айхтар - айхавтар, аймхай - аймтгай, бэлхэн - бэлээхэн” зэрэг жишээг дурджээ (Базаррагчаа 2017: 143). Энэ мэтчилэн хэлэлцэхийн явцад “хо-ол газар”, “хол-оо газар” гэх мэтээр уул үгийн аль нэг авиаг онцлон чухалчилдаг шинжийг аман ярианд олон янзаар хэлж болно.

Дэд авиалбарт үгс нь дуудлагын онцлогоос үүдэн найруулга хэрэглээний ялгаа илэрхийлэх үүрэгтэй бөгөөд хэлэнд илүү нэлээд тогтвортой болоод ирэхээр толь бичгүүдэд толгой үгээр ордог байна. Монгол хэлний толь бичгүүдэд нэг үгийн олон бичлэг, дуудлагыг аль алиныг оруулсаар ирсэн байна. Ийнхүү нэг үгийн олон хувилбар нь толь зохиох ажилд нөлөөлдөг талаар Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв нар "Монгол шинэ бичгийн хэлэнд нэгэн мөр болж чадаагүй олон янзаар бичиж, дуудах үг нэлээд байдаг. Энэ явдал манай толь бичигт бас нөлөөллөө. ...Цаашид эдгээр үгийн зарим нь нэг мөр бичлэгтэй болох ба зарим нь өөр бичлэгтэй, өөр утгатай болж хөгжих бололтой" (Дамдинсүрэн, Лувсандэндэв 1982:3) хэмээн эдгээр үг нь зарим тохиолдолд бие даасан утга илэрхийлж, тусдаа үг болон хөгжиж болохыг дэвшүүлсэн нь орчин цагийн монгол хэлэнд биеллээ олсон зарим үгийг дурдсан хэрэг.

# МОНГОЛ ХЭЛНИЙ ЯЛГАХ ЁС НЭРИЙН ХЭЛЦЭД ИЛРЭХ ТУХАЙ

*Базаржавын Пүрэвсүрэн*
*(МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*

Нэр үгийн хэл зүйн айн нэгэн чухал шинж нь онцлон ялгах, тухайлан ялгах ёс юм. Энэ илтгэлээр монгол хэлний нэр үгийн ялгах ёс буюу нэр үг, тодотгол гишүүний өгүүлбэрийн харилцаа холбоог үүсгүүр өгүүлбэр зүйн аргаар шинжилсэн судалгааны үр дүнг танилцуулахаар зорилоо.

Онцлон ялгах болон тухайлан ялгах утга хүн төрөлхтний хэлэнд нийтлэг шинжтэй үзэгдэл бөгөөд тоо, хүйсийн ай зэрэг түгээмэл айн нэгэн адил нэр үгийн хэлбэржих хэл зүйн тусгайлсан бүтээвэргүй хэлэнд ч нэрийн зарим тодотголоор илэрдэг. Ялгах ёс хэлний хэрэглүүрээр илрэх байдал нь олон хэлэнд түгээмэл зүй тогтолтой. Тухайлах, эс тухайлах ялгац болон нэр үгийг тухайлан ялгах үүрэгтэй залгавар болон угтвар бүтээвэр нь ялгах утга хэл зүйн айд илрэх гол арга хэрэгсэл болдог. Хэл зүйн аргаар ялгах ай илэрдэггүй хэлэнд биеийн төлөөний нэр, заах болон хамаатуулах төлөөний нэр, тооны нэр тодотгогч, заахын тийн ялгалын нөхцөл зэрэг хэлний нэгж ялгах, тухайлах утга илэрхийлдэг.

Монгол хэлэнд ялгах ёс илрэх онцлогийг академич Ш.Лувсанвандан тэргүүлэн судалж, 1953 онд хэвлүүлсэн “Монгол хэлэн дэх ялгах ба үл ялгахын ёсон” өгүүлэлдээ “...нэрийн зүйлийг өгүүлбэрт хэрэглэхдээ өгүүлэгч, сонсогч этгээдийн сэтгэлд уул юмны нэрийг тухайн төрлийн олон юмын нэрсээс онцолж ялган заах буюу эсвэл тэгж онцлон ялгахгүйгээр тухайн төрлийн нэг юмын нэр болох төдийг заах” (Лувсанвандан, 1953) үг зүй, өгүүлбэр зүйн аргуудыг судалгааны баримт, жишээгээр шинжлэн тайлбарлажээ.

Ялгах ёс буюу “ялгах ба үл ялгахын категори” нэр үгийн заахын тийн ялгалаар хэлбэржих аргыг онцлон шинжлэхийн зэрэгцээ нэр үгийн зарим тодотголоор илэрдэг болохыг шинжлэн тогтоосон. Монгол хэлний нэр үгийн зарим

тодотгол ялгах ёсыг илтгэх бөгөөд нэрийн тодотгол бүр ялгах ёсыг илэрхийлдэггүйг ажиглан тогтоожээ. Академич Ш.Лувсанванданы тодорхойлон тогтоосноор:

- үйлт нэрийн тодотгол, болон гишүүн өгүүлбэр,
- зүг, чиг огторгуйн холбогдол бүхий утгатай дутмаг нэр тодотгол,
- биеийн төлөөний нэрийн харьяалахын тийн ялгалын хэлбэрт тодотгол, заах төлөөний нэр тодотгол, асуух төлөөний нэр эдгээр нэгж ялгасан утгатай болохыг тайлбарласан.

Бид үүсгүүр хэл зүйн онол, арга зүйд үндэслэн нэр үгийн тодотголыг ангилж, ялгах ёс илтгэх тодотгол бүрдүүлбэр өгүүлбэрийн холбоо харилцааны хувьд бусад тодотголоос утга, үүргийн хувьд ялгаатай болохыг шинжилсэн болно. Судалгаанд хэлцийн бүтцийн X’ (X-bar) (Chomsky, 1970) онолыг үндэслэл болгож хэлцийн бүтцэд үгийн сангийн утга агуулдаг үгс болох хэлцийн толгой бүрдүүлбэр (head) болон түүний утгыг дэлгэрүүлэх үүрэгтэй нэмэлт тодотголоос гадна үгийн сангийн утгагүй үгс буюу үүргийн айн нэгж болох тодотгогч бүрдүүлбэрийн синтактикийн байрын ялгааг загварчилсан арга зүйн дагуу өгөгдлийн санд шинжилгээ хийх зорилго тавьсан.

“Монгол хэлний нэрийн бүлгийн задлуурыг модны сангаас үүсгэх нь” төслийн хүрээнд өгүүлбэрийн гишүүдийг нэрийн, үйлийн болон бусад дэд бүлэгт хуваах үйлдэл хийх, өгүүлбэрийн бүлгийн задлал хийх туршилтад ашигласан өгөгдлийн санд шинжилгээ хийхдээ монгол хэлний нэрийн тодотголыг үзүүлж буй харьцааны гол утгыг “Монгол хэл судлал, Өгүүлбэр зүй” (2022:146) бүтээлд дурдсан дагуу ангилсан. Тус ангилалд нэр үгийн тодотголыг чанар, тоо хэмжээ, овор хэлбэр, хэмжээ, бүтсэн эд, өнгө, орны харьяалал, цагийн харьяалал, шинж, үйл хөдлөл заасан утгыг бүлэглэн тодотгол ангилалд оруулах, эзний харьяалал заасан болон төлөөлөн заасан утгатай гишүүдийг онцлох, тухайлан ялгах утга илэрхийлсэн утгатай хэмээн бүлэглэсэн. Эдгээр бүлэгт хамаарах тодотгол гишүүдийн хэрэглээний байрыг шинжлэн, тоон харьцааг гаргасан.

Уг тооцоо болон үүсгүүр өгүүлбэр зүйн аргаар шинжилсэн үр дүнг харьцуулан, монгол хэлний ялгах ёс нэрийн хэлцэд илрэх онцлогийн талаарх ажиглалт, дүгнэлтийг энэ илтгэлд танилцуулахаар зорилоо.

# ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН МОНГОЛ НЭР ТОМЬЁО БҮРЭЛДСЭН НЬ

*Доктор (Ph.D) Батмөнхийн Дэлгэрмаа*
*(ШУТИС-ийн Гадаад хэлний сургууль)*

Жилийн ихэнх хугацаанд хүйтэн сэрүүн цаг агаартай Монгол орны хувьд эрчим хүч нь чухал бөгөөд цаашид улам өргөжин шинэчлэгдэх салбар юм. Өнөөгийн байдлаар дулааны цахилгаан станцууд голлон эрэлт хэрэгцээний ачааллыг үүрч байгаа боловч усан, нарны, салхин цахилгаан станцуудыг байгуулан цахилгаан үйлдвэрлэсээр байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд эрчим хүчний салбарын нэр томьёог УНТК-ын мэдээ, албан ёсоор батлагдан хэвлэгдсэн нэр томьёоны толь бичиг, их дээд сургуулийн мэргэжлийн ангид үзэх ном, сурах бичгээс түүвэрлэсэн эрчим хүчний салбарын нэр томьёо, Монгол Улсад эрчим хүчний салбар эрчимтэй хөгжсөн үеийн түүхийг ажиглан авч үзлээ. Эрчим хүчний салбарын нэр томьёонд орос, англи, герман, франц зэрэг хэлнээс гадна хятад хэлнээс олон үг шууд буюу монгол хэлэнд нэвтрэн, бүр нутагшжээ.

Эрчим хүчний салбарын нэр томьёог ажиглахад дагаврын, үг нийлэх, үг хураах зэрэг үг зүйн арга, уугуул монгол үгийг нэр томьёоны үүргээр хэрэглэх, харь хэлний үгийг зээлдэн авах, хуулбарлан авах зэрэг үгийн сан, утга зүйн аргаар нэр томьёо оноож байгаа нь монгол хэлний үгийн санг баяжуулдаг бүхий л арга хэлбэртэй тохирох бөгөөд шинжлэх ухааны аль ч салбарын нэр томьёо үүсдэг нийтлэг аргуудтай нийцэж байна. Мөн концепт нь объектын (денотатын) нийтлэг шинж чанар ба онцлох талын нэгдлийг илэрхийлсэн нэр томьёо олон байна.

Түүнчлэн эрчим хүчний салбарын нэр томьёоны санд уугуул монгол үгээр оноосон нэр томьёоноос гадна шинжлэх ухааны тогтсон гадаад нэр томьёо болон монгол үгийн нийлэмж, гадаад үгэнд монгол үгийн залгавар залгаж, мөн монгол үгэнд гадаад үгийн залгавар бүтээвэр залгаж оноосон

нэр томьёо цөөнгүй. Сонирхолтой нь хураах аргаар үүссэн нэр томьёо хоёр байна. Эрчим хүчний салбарын нэр томьёо нь ажиллах зарчим, зориулалт, үзэгдэл, ухагдахуун болон юмст хамаарч буй шинжээр нь оноон нэрлэсэн монгол нэр томьёо олон ажээ. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд нэр томьёо оноохдоо эхлээд зориулалтаар нь нэрлэж, улмаар түүний ажлын үндсэн эрхтний байдал ба (буюу) түүнийг ажиллуулж байгаа эрчмийн төрлийг заасан нэрийг хавсарган хэрэглэх зарчмаар үүссэн нийлэмж үгээр бүтээх арга түгээмэл ажиглагдав. Ажлын эрхтнээр нь алхан, булт, үрлэн, гулуузан гэсэн болон ажиллуулж байгаа эрчмийн төрлөөр цахилгаан, салхин, усан гэсэн хавсрал нэр бүхий нийлэмж үг байна.

Цаашид гадаад улс оронтой хамтрах шинэчлэл, өөрчлөлтийн хүрээнд өргөжиж буй эрчим хүчний салбарт харь хэлний үг, нэр томьёо улам олон орж ирэхтэй холбогдуулан тухайн салбарын мэргэжилтнүүд, хэл шинжээч судлаачидтай хамтран ажиллах шаардлагатай ажээ.

# ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ШАР ӨНГӨ ЗААСАН НЭРИЙГ АВАЛЦУУЛАН ХОЛБОХ АРГААР СУДЛАХ НЬ

*Доктор (Ph.D) Осоржамаагийн Нандин-Эрдэнэ*
*(ШУТИС-ийн Эрдэнэт цогцолбор дээд сургууль)*

Авалцуулан холбох туршилтын арга (лат. Associare-нийлүүлэх, англи. associative experiment) нь сэтгэл судлал, сэтгэцийн эмгэг судлалын салбарын нэр томьёо байсан бол сэтгэл судлал болон хэл шинжлэлийн уулзварт бий болсон сэтгэц хэл шинжлэлийн судалгаа хийх болсноор уг салбарын үндсэн аргын нэг болсон байна. Энэ аргаар 1879 онд анхны туршилт хийсэн хүн бол Ч.Дарвины үеэл англий сэтгэл зүйч Ф.Гальтон (Francis Galton) болох тухай В.П.Белянин "Психолингвистика" номын "Эксперимент в лингвистике" бүлэгт өгүүлжээ. "Толковый словарь психиатрических терминов" толь бичигт тэмдэглэснээр (http://psychiatry.academic.ru/) W.Wundt, И.М.Сеченов нар ч энэ туршилтын анхдагч ажээ.

Авалцуулан холбох аргаар туршилт хийж үр дүнг толь бичиг болгосон Ж.Дийз (J.Deese) "The structure of associations in Language and Thought", Baltimore, 1965; "Словарь ассоциаций собранных в вручную на основе коллективного ассоциативного эксперимента"; "Словарь ассоциаций"; "Сеть словесных ассоциаций" зэрэг тусгай толь бичиг байна. Дээрх толь бичгүүдэд эхлээд толгой үг (дохио үг) өгч түүнд харгалзах хариу үгсийг давтамж буурах байдлаар жагсаана.

Авалцуулан холбох туршилтын үр дүнг тайлбарлах олон боломж бий. Бидний 1-р туршилтад өнгө заасан дохио үг өгч хариу үг авсан нь "дохио үг – хариу үг" загвараар өнгө заасан нийлэмж үүсэж буй 1-р арга юм. Жишээлбэл, бид дохио үг болгон "шар" гэх үг өгөхөд туршилтад оролцогч хариу үг бичсэнээр "шар"+"өрмөн" = "өрмөн шар" (жинхэнэ нэр +өнгө заасан нэр) гэж хариу үг үүсэж байгаа нь эдгээр нэр өөр хоорондоо холбогдож шугаман бүтцийн харьцаанд орох

боломжтойн илрэл болно. Үүнчлэн аль нэг үг хэллэг тархинд түүнтэй авалцан уялддаг, монголчуудын сэтгэлгээнд хэвшсэн нийлэмж авалцуулан холбох аргын туршилтаар гарч ирнэ гэж үзсэн.

Авалцах холбоо нь хүний санах ойд тогтмол байдаг аливаа зүйл, үйл явдал, юм, үзэгдлийн хоорондын уялдаа бүхий хүний оюун ухааны холбоо юм. Энэ нь хоёр өөр үгийн аймаг (жинхэнэ нэр + тэмдэг нэр) нийлж нийлэмж үүсгэх буюу шугаман бүтцийн харьцаа үүсгэж байна. Үүний цаана аль нэг үгийг хэлэхэд тархинд түүнтэй авалцуулан уялддаг, нийлэмж үүсгэх үгийг бид сонгосон ба монголчуудын сэтгэлгээнд хэвшсэн нийлэмж авалцуулан холбох аргын туршилтаар гарч ирнэ гэж үзсэн. Авалцуулах холбоо нь хүний санах ойд тогтмол байдаг аливаа зүйл, үйл явдал, юмс үзэгдлийн хоорондын уялдаа бүхий хүний оюун ухааны холбоо юм. Энэ туршилтын зорилго нь үгийн сангийн нэгжүүдийн харилцан хамаарал, авалцан холбогдох зүй тогтлыг олж тогтоох явдал болно.

# МОНГОЛ, ТУВА БӨӨГНӨЛ ҮЛГЭРҮҮД

*Доктор (Ph.D) Мягмарсүрэнгийн Ууганбаяр*
*(МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*

Дэлхийн аман зохиолд үлгэрийн өгүүлэмж мөчлөгөөр давтах бөөгнөл /кумуляция/ гэх арга буй. Бөөгнөл үлгэрт кумулятивная сказка шинэ дүр, дүрүүдийн тоо нэмэгдэх зэргээр үйл явдал олон дахиж давтагддаг. Бөөгнөл үлгэр бол үлгэрийн нэг зүйл бөгөөд германчууд /Zahlmarchen/ эргэц үлгэр гэж нэрлэх ажээ.

В.Я.Пропп бөөгнөл үлгэрийн хүүрнэх бүтэц зохион байгуулагдах үндсэн зарчмыг гинжин хэлхээ алдрах тасалдах хүртэл эсвэл сүлжих дэс дараа өөрчлөгдөх хүртэл нэг адил үйл явдлууд буюу махбодууд олон дахин давтагдах шинжээр тодруулжээ. (Пропп 1976:243) Бид урьдах өгүүлэмж адил хэд хэдэн бөөгнөл бүтэцтэй үлгэрийг ялган харуулав.

Аман зохиол судлаач гадаадын эрдэмтэд монгол халимаг буриад тува бөөгнөл үлгэрийг судалжээ. Д.А.Носов монгол буриад бөөгнөл үлгэрийг, Т.Г.Басангова, Д.В.Убушиева, Б.Б.Манджиева нар халимаг бөөгнөл үлгэрийг, Б.-Х.Б.Цыбикова буриад бөөгнөл үлгэрийг судалжээ. (Носов 2010: 87, Носов 2011: 19-21, Басангова, 2002: 193-195, Басангова 2018: 51-52, Басангова, Манджиева 2011: 177–188, Манджиева 2011: 100-106, Убушиева 2017: 139-151, Цыбикова 2020: 433) З.Б.Самдан тува үлгэрийн эмхэтгэлдээ хэд хэдэн тува бөөгнөл үлгэрийг ялган тодруулжээ. (Самдан 1994: 380-392)

Бидний харьцуулан авч үзэж буй “Мөнгөн ташаатай хулгана” гэх монгол үлгэр “Күскениң шинчилели” (Хулганын бодол) гэх тува үлгэр адил өгүүлэмжтэй бөөгнөл хувилбар үлгэрүүд юм.

# ОНЬСОГЫН ШҮЛЭГЛЭГ ШИНЖ БА ШҮЛГИЙН ОНЬСОГОЛОГ ШИНЖ

*Оюунтын Болор-Эрдэнэ*
*(ӨМБИС-ийн Монгол судлалын дээд сургууль)*

Оньсогыг ардын аман зохиолын хүрээнд багтааж тайлбарлах нь олон. Гэхдээ оньсогод хадгалагдаж байдаг шүлэглэг шинжийн талаар эрдэмтэд судлан шинжилж, тусгайлан өгүүлэл шүүмж бичин нийтлүүлж байсангүй. Иймээс оньсогын шүлэглэг шинжийг одоо үеийн шүлгийн шүүмжид түлхүү хэрэглэдэг айзам хөг, имижийн бүрэлдэл, далд зүйрлэлийн илрэл зэрэг хэдэн талаас задлан шинжлэх нь шинэ үр дүнг олох боломжтой юм. Үүний сацуугаар шүлгийн оньсоголог шинжийг ардын аман зохиолын судалгааны аргаар, тэр тусмаа оньсогын онол ойлгогдохуунаар тайлбарлан судалж, оньсого болон шүлгийн харьцаа холбоо, ялгаа зөрөөг улам нэг алхам тодолж, ардын аман зохиол дахь одоо ч буй элемент ба шүлэг дэх ардын аман зохиолын уламжлалыг хайн сүвэгчлэх нь эрдэм шинжилгээний ач холбогдолтой гэж үзэж байна.

# “ЖАНГАР” ТУУЛЬ ДАХЬ УРИА ДУУДЛАГА, САХИУСААР ХҮЧИЙГ ИЛТГЭХ ҮЗЭЛ УХАМСАР

*Доктор (Ph.D) Викторын Янжиндулам*
*(МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургууль)*
*Лхагважавын Гүндсамбуу*
*(МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*

Энэ өгүүлэлд Б.Дамиранжавын эрхлэн текст харгуулал, үгсийн тайлбарыг үйлдсэн “Халимаг Жангар”-ын эх материалд тулгуурлан тууль дахь хүчийг илэрхийлэх зарим үзлийг тайлбарлав. Ялан дийлдэх эгзэгтэй үед уриа дуудлагаа дуудсанаар тулгарсан саад бэрхшээлийг даван туулж байгаа гэсэн итгэл үнэмшил нь балар эртний хамтын төсөөллийн пралогик сэтгэлгээний ул мөр бол Алдар Жангарын ариун цагаан мирд, нутгийн заяа сахиусанд даатган залбирснаар ялан дийлэх хүчийг олно гэсэн итгэл үнэмшил нь туулийн хөгжлийн хожуу үед бурхны шашны үзэл санааны нөлөөгөөр бий болжээ.

## “БОДЬ ГАЛАВ ХААН” ТУУЛЬ ДАХЬ МАНГАСЫГ ГАЛААР ДАРАХ ӨГҮҮЛЭМЖ, ТҮҮНИЙ УТГА БЭЛГЭДЭЛ

*Хосбаяр*
*(МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*

Хорчин угсаатны дунд түгээмэл хайлагддаг “Бодь галав хаан” гэх монгол баатарлаг туулийн шүлэглэлд “гал”, галтай холбогдолтой дүр, төлөв байдал, үйл хөдлөл, эдлэл хэрэглэл, зан үйлийн өгүүлэмж олонтоо тохиолдог. Энэхүү галын тухай өгүүлэмж нь тус туулийнхаа эхлэл болон төгсгөлийн өгүүлэмжүүдийг өөр хооронд холбож өгсөн өвөрмөц хэлбэртэй болох нь харагдана. Тус өгүүлэлд туулийн баатрын хүлэг унааны гүйдэл, харайлт, ааш араншинг бадран асаж буй “галтай” холбон дүрслэх, мангасыг галаар шатаан сөнөөснөөр туулийн хэсэг өндөрлөх гэх мэт галтай холбогдолтой бүхий зүйлийн утга учир, зан үйлийн бэлгэдэл, соёлыг тайлан шинжилж, монголчуудын галын тухай соёл, зан үйлийн талаар нарийвчлан өгүүлэхийг хичээсэн болно.

# ШИНЖААНЫ ХОВОГ САЙРЫН УРТЫН ДУУН ДАХЬ МОРИНЫ ЗҮС ЗААСАН ҮГСИЙГ БЭЛГЭДЭЛ ЗҮЙН ТАЛААС АВЧ ҮЗЭХ НЬ

*Нимгэрийн Бадамцэцэг*
*(МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*

Алтай уулын баруун сугад нутаглаж байгаа Ховог сайрын монголчууд бол арван долоодугаар зууны далаад оноор ижил зайнаас буцаж ирсэн торгуудууд Цэвэгдоржийн үе хойч болно. Энэ нутгийн хөрсөн дээр уе улиран амьдарч ирсэн ард түмний дотроос олон арван шүлэгч, жангарч, ерөөлч, дуучид түрэн гарч Ховог сайр нутгийнхаа түүх соёлыг олны хүртээл болгосоор иржээ. Ховог сайрын торгууд ардын дуучдын нэгэн төлөөлөл Н.Намжав (1954-2001) хэдийгээр хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн ч түүний дуулсан дуунууд ард түмний сэтгэлд мөнхийн өв болон үлдсэн юм. Судлаачид ардын дуучин Н.Намжавын дуулсан дуунуудыг цуглуулан эмхэтгэж, намтар түүхийн тухай танилцуулж байсан ч түүний дууг утга агуулгын үүднээс задлан шинжилж байгаагүй учраас бид энэхүү сэдвийг сонгосон болно. “Монгол ардын дуунд мориор гол дүрслэгдэхүүн болгож, мориноос салсан дуу тун ховор байдаг. Тэрчлэн монгол ардын дуунд үйл хэрэг, хүсэл эрмэлзлийг гол биелүүлэгч нь гарцаагүй морь байдаг” тул Н.Намжавын дуулсан дуунуудаас “Баруун монгол ардын дууны уламжлал ба түүх соёлын хувьсал” номд Д.Бат, Л.Дангажав нарын оруулан эмхэтгэсэн найман дуунаас морины зүсмээр утга агуулгаа баяжуулан бэлгэдсэн гурван дууг нь сонгож, задлан шинжлэв.

Энэхүү өгүүлэлдээ Ховог сайрын монгол өөртөө засах сумын торгууд ардын дуучин Намжаагийн Намжавын намтар, уран бүтээлийн талаар товч өгүүлж, түүний дуулсан дуунуудаас 1. Найр хуримын дуу, 2. Нутаг усны дуу, 3. Янаг амрагийн дуу гэсэн гурван сэдвийн хүрээнд найр хуримд дуулагддаг, морины зүсмийг онцолсон гурван дууг онцлон авч задлан шинжиллээ. Эдгээрээс харахад монголчуудын дунд өргөн тархсан зүсмийн бэлгэдэлт утгыг уусган шингээсэн энэхүү гурван дуу нь утга

агуулгын хувьд дууг баяжуулж, хүний сэтгэлийн өнгө аясыг улам тодоор илтгэн өгч байна. Морь бол монголчуудын мал аж ахуйн хамгийн чухалд тооцогдох, нөгөөтээгүүр сэтгэл санаанд хамгийн ойр дотно адгуусан амьтан тул ийнхүү баяр жаргалтай, уй гунигтай ямар ч үед дуулах дуунд нь морины тухай өгүүлэмж, дүрслэл чухал байр суурийг эзэлж байна.

# “ЭРХИЙ МЭРГЭН” ҮЛГЭРИЙН МОТИВЫН СУДАЛГАА

*Сэцэнтунгалаг*
*(МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль)*

“Эрхий мэргэн” домог үлгэрийн судалгаа харьцангуй эрт үед эхэлжээ. Үүнд Оросын монголч эрдэмтэн Г.Н.Потанин 1916 онд Томск хотноо “Еркэ. Культъ сына неба въ Северной Азіи” номоо түрэг-монголын домог үлгэрийн баялаг эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан бичсэн билээ. Түүнээс өмнө буюу 1872 онд мөн Оросын хятад судлаач Палладий “Восточний сборник” номдоо Е Ли ку унь хэмээх үгийг онцолж, тухайн цагийн Хятадад христийн шашныг энэ нэрээр нэрлэж байсан гээд түүнийг түрэг хэлний “еркеунь”, монголын “архаунь” гэдэг үгийн хятад хувирсан хэлбэр (Дорнын эмхэтгэл //Старинные следы христианства в Китай. 1872. Т 1, стр. 27) гэж үзсэн байна. Энэ бүхнээс үүдэж монгол болон хятадын домог үлгэрийн сангаас “нарыг харвасан” тухай мотив бүхий жишээг сонгон харьцуулж үзэхийг гол болгов.

Нарыг харвасан тухай мотив нар, тарвага, морь, эр хүн, эртний овог аймгийн хоорондох тулалдаан зэрэг олон сэдэвт хамааруулан үзэж болно. Монгол оронд “Эрхий мэргэн”-ний домог-үлгэр өргөн дэлгэрчээ. Бид нийт 6 хувилбарыг олж тэмдэглэв.

Хятад үндэстний эртний түүх бичигт нарыг харвасан тухай зүйл тэмдэглэгдэн үлдсэн төдийгүй аман хэлбэрээр хан үндэстнээс гадна Өмнөд орны Бү И (布依族), донг (侗族), бланг (BL), эй, маонань (MNN), яо (YA), лису (LS), ачан (AC), гаошан (GS) зэрэг үндэстэн, мөн умард зүгийн монгол, манж, орчан зэрэг үндэстэнд энэхүү домог дэлгэрсэн нь бүртгэгджээ.

Монголчуудтай хөрш зэргэлдээ зүүн өмнөд Азийн зарим улс үндэстэн, эртний Энэтхэгийн нарны тухай домог үлгэрт олон нар зэргээр гарч газар дэлхийг шатаам болсон гэх мотив цөөнгүй тааралдана. Ер нь олон нар гарч дэлхий ертөнцөд хүн, амьтан байх эцэсгүй болж амьдрал байхгүй болоход тулсан гэдэг бол энэ домог үлгэрийн үндсэн мотив юм.

Ганц нарны тооны хувьд авч үзэхэд, сонирхолтой зэрэгцүүлэл харагдаж байна. Монгол орны олон угсаатны дунд тархсан энэхүү домгийн 6 хувилбар дахь нарны тоог үзвэл 1-12 хүртэл нар гарч дэлхий өгүүлжээ. Гэхдээ Хөхдэй мэргэний домог үлгэрт ах дүү долоогийн бага Мэргэн харваач нар, сарыг (тус бүр нэг) харвахыг завдсан гэж гарна. Дээрх хувилбаруудад нэг, гурав, долоо, найм, арван хоёр хэмээн гарах бөгөөд гурван нар гэх тоо хоёр удаа давтагдаж байна.

Хятадын газар нутагт дэлгэрсэн хувилбаруудаас дээрх домгийн эртний бичгийн дурсгалд “И арван нарыг харвасан нь” (есөн нарыг харвасан) гэх домог бий. Энд “арван нар зэргээр мандсан” гэж гардаг. Бидний бүртгэн шүүсэн бүрэн бус жагсаалтаар, хан үндэстнээс гадна бусад цөөн тоот үндэстний хэмжээнд Ше хэмээх үндэстэнд арван нэг, И үндэстэнд долоо, Зуван үндэстэн арван хоёр ба арав ес, Бү И, Дүн үндэстэнд арван хоёр, Гелу нарт долоо, Мао нань хийгээд Яо нарт арав, Мяо нарт найман нар, найман сар, арван хоёр нар, арван хоёр сар, Лис үндэстэнд есөн нар, долоон сар, Нааш хэмээх үндэстэнд арван хоёр нар гэхчлэн тохиолдож байна. Мөн манж үндэстэнд есөн нар, эхже хэмээх зүүн хойдын үндэстэнд гурван нар, орчанчуудад арван хоёр нар гэж гардаг.

Дээрх мэт угсаатны хэмжээгээр авч үзэхэд 12 нар гэх тоо хамгийн олон давтагдалтай буюу зургаан удаа тохиолдож байна. Цааш хөөж үзвэл, Зүүн өмнөд Азийн зарим улс, үндэстэн тухайлбал, Энэтхэгийн нар сарны тухай мифэд олон нар нэгэн зэрэг мандсан тухай мотив, эртний бархман шашинтны домог үлгэрт арван хоёр нар, бурхан шашны мифэд долоон нар гэж өгүүлсэн нь бий.

Монгол домог дахь нарны тоог дээрх улс үндэстнийхтэй харьцуулж үзэхэд нарны тоо нь Хятадын олон үндэстний төдийгүй Энэтхэгийн од эрхсийн домог үлгэр дэх 12, 7 гэсэн тоотой давхцаж байгаа нь анхаарал татаж байна.

Олон нар гарсан шалтгааныг авч үзэхэд, монгол үндэстний таван хувилбарт олон нар аяндаа мандсан гэж, нэг хувилбарт олон нар мандаж байжээ гэж гарна. Ганцхүү Зуу-Удын хувилбарт хурмаст тэнгэр хүмүүн ба амьтныг яллахын

тулд арван нэгэн нарыг тэнгэрт мандаасан гэжээ. Хятадын ганц нэг үндэстний домогт тэнгэр сахиусан туурвигч баатар, эсвэл чөтгөр шулам олон нар гаргажээ гэжээ. Жишээлбэл, манж үндэстний нэгэн домог үлгэрт тэнгэр, шавь нартаа ертөнцийн хүн төрөлхтөнд "нар зохиож өг" гэж томилон явуулсанд, олон шавь нь зохиосоор байгаад есөн нар зохиочихжээ гэдэг. Илтгэлд дээрх мэт мотивуудыг цааш зэрэгцүүлэн авч үзсэн болно.

# ҮЗЭМЧИН УРТЫН ДУУНЫ ЯРУУ НАЙРАГ ДАХЬ СОЁЛЫН УТГЫГ ТАНИХУЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ

*Тогтох*
*(СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль)*

Өнөөдөр угсаа-хэл шинжлэл, соёл-хэл шинжлэл, танихуй хэл шинжлэлийн чиглэлүүд хөгжиж энэ нь урлаг ба соёлын судалгаанд шинэ боломжуудыг нээн өгч байгаа юм.

Угсаатны хөгжим судлалын чухал нэгэн судлагдахуун нь ардын дууны шүлэг (текст) бөгөөд түүнийг хэлний баримтад түшиглэх нэг хэрэг, харин хэлний объектив байдлаас гадна оршиж байдаг зүйлсийг авч үзэх нь өнөөдөр чухлаар тавигдах боллоо. Тухайлбал, үзэмчин ардын дууг судлахад дуу өөрөө өгүүлэхүйн эрхтнээс үүдэн бүтсэн, ая эгшгийн эрэмбэлэгдсэн систем буюу аялгуу, мөн үг хэлний дохио тэмдэгтийн тогтолцооны зэрэгцээ түүнээс гадна оршиж байгаа зүйл гэдэгт систем, дохионы код зэргийг хамааруулбал илүү нарийн судалгаа болно.

Үзэмчин ардын дууны яруу найргийн шүлэгт зарим ажиглалт хийхэд дүрслэл, багтаамж, илэрхийлэл нь үзэмчин хүний үзэл баримтлалын хүрээнд нэвтрэх, тэдний соёлын үндсэн загварууд оршин тогтнох, гарч байгаа өөрчлөлтийг судлах боломж юм.

# Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН ЭРДМИЙН АЖЛЫН ӨВ-МОНГОЛ УЛСАД РАВЖАА СУДЛАЛЫН ЭХИЙГ ТАВЬСАН НЬ

*Доктор (Ph.D) Гаадамбын Билгүүдэй*
*(ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн)*

XIX зууны эхний хагаст Монголын уран зохиолын түүхэнд нэгэн баларшгүй авьяас билигт бичгийн мэргэн мэндэлсэн нь хожим олноо Говийн Догшин ноён хутагт Равжаа хэмээн алдаршжээ. Равжаа нь хутагт хүн байсан бөгөөд шүлэг зохиолоо монгол, төвөд хоёр хэлээр туурвиж үлдээжээ. Тэгвэл Говийн догшин ноён хутагтын шүлэг, дуулал, сургаал, жүжгийн зохиолыг нь орчин үеийн утга зохиолын онолын үүднээс судлан тодруулах эрдэмтэн зохиолч нь Равжаа мэндэлснээс хойш 105 жилийн хойно 1908 онд мэндэлсэн нь Цэндийн Дамдинсүрэн байжээ.

Академич Ц.Дамдинсүрэн нь Равжаа мэндэлснээс хойш 105 жилийн дараа мэндэлсэн хэдий ч Монголын уран зохиол, түүний гарамгай төлөөлөгчдийг орчин үеийн шинжлэх ухаанч арга барилаар судлан дэлгэрүүлэх ажлыг XX зууны дунд үеэс буюу Равжаа хутагтыг дүрсгүйн оронд шилжин өөд болсноос хойш 100 гаруй жилийн дараа эхлүүлсэн юм.

Академич Ц.Дамдинсүрэнгийн Равжаа судлалыг эхлүүлээд зогссонгүй өөрийн араас олон шавь судлаачдаа удирдан чиглүүлснээр Д.Цагаан, Ч.Алтангэрэл, Д.Цэрэнсодном, Д.Ёндон, Л.Хүрэлбаатар, Р.Отгонбаатар, С.Хөвсгөл нарын олон эрдэмтэн мэргэд Равжаа судлалаар судалгааны бүтээл туурвин Равжаа судлал дэлгэрэн хөгжиж буй билээ.

# ЮАНЬ ГҮРНИЙ ЖҮЖГИЙН ЗОХИОЛЫН ӨРНӨ ДАХИН ДАХЬ СУДАЛГАА

*Доктор (Ph.D) Бямбасүрэнгийн Хишигсүх*
*Эрдэнэжаргалын Сурнаа*
*(МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*

When looking at the study of dramas of the Yuan Dynasty in the West, there are many that have analyzed the Chinese culture and history, but there are very few that have been studied in relation to the Mongolian nation. Since the Yuan dynasty was ruled by the Mongols, it is clear that the background of that society influenced the development of the drama of that time. Although Western William Dolby and Crump agreed with this view, they failed to address other issues influenced by other aspects of Mongolian culture and history. But Stephen H.A group of scholars, headed by West and Chung-Weng Shi, believed that the composition of Yuan's plays had nothing to do with the Mongol status of his ruler. Western drama researchers of the Yuan Dynasty created a new color in the field of drama research in the Yuan Dynasty with their unique academic methods and theoretical concepts.

Research has led to the training of researchers in philosophy, social science, and anthropology, including logic, accounting, and mathematics. It was innovative in that it began to study Yuan drama in the West in a multidisciplinary context.

# БЕЛАРУСЬ БИЧВЭРТЭЙ ЗЭРЭГЦҮҮЛСЭН “МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО” НОМЫН ҮНДСЭН ҮҮРЭГ

*Доктор (Ph.D) Владимир Куликович*
*(Беларусийн Улсын Технологийн Их Сургууль)*

Монголын уран зохиол нь Беларусийн уншигч олонд төдийлөн танил биш. Үүнийг орчуулгын уран зохиолын хэвлэлтийн динамик баталж байна. Тийм боловч хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн том гүрнийг үндэслэгч, их эзэн богд Чингис хааны нэрийг манай улсын маш олон хүн мэддэг. Гэхдээ энэ талаарх мэдээллийг Их Британи, Герман, Казахстан, Хятад, Монгол, Польш, Орос, Япон зэрэг улсад гарсан орос хэлээрх ном, сурах бичиг, түүхэн роман, кино бүтээлүүдээс мэдсэн байдгийг тэмдэглүүштэй. Өөрөөр хэлбэл, монгол, түрэг овог аймгуудыг нэгтгэсэн энэ агуу хүний тухай ном зохиол, кино бүтээл беларусь хэл дээр хараахан гараагүй байна. Тиймээс манай орны хэвлэлийн практикт үүссэн энэ цоорхойг арилгах зорилгоор Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Батсүхийн Баярсайханы санаачилгаар Монголын эртний уран зохиолын дурсгал “Монголын нууц товчоо”-ны беларусь бичвэртэй зурагт номыг бүтээх ажлыг эхлүүлэхээр болсон юм. Энэхүү төслийг боловсруулах ажлыг Беларусь Улсын Технологийн Их Сургуулийн хянан тохиолдуулалт, хэвлэлийн технологийн тэнхим хариуцан ажиллахаар болов. Беларусь, Монголын “соёлын харилцааны” чухал хэрэгсэлд орчуулгын тухай ойлголтыг бий болгож, орчуулсан эх бичвэрээ "шинэ утга санааг үүсгэгч" болгохыг зорьж байгаад уг төслийн ач холбогдол оршино.

Бид энэхүү илтгэлдээ Беларусийн ном хэвлэл, соёлын амьдралд "Монголын нууц товчоо" номын гүйцэтгэх үндсэн үүргийг тодорхойлохыг зорилоо.

# ӨВӨР МОНГОЛЫН ОРЧИН ЦАГИЙН ТУУЖ, ӨГҮҮЛЛЭГИЙН ТУУРВИЛ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

*Доктор (Ph.D) Шараагийн Баттөр,*
*Саранчимэг (МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*

М.Мөнхөөгийн зохиол бүтээлд урадын уул ус, малчин ард, тэдний зан үйл нүдний өмнөх зураг шиг тодхон. Түүний зохиолд урадчуудын амьдрал, соёл сэтгэцийг тусгах, нүүдэлч амьдралаас суурин соёлд шилжиж буй хүн ардын сэтгэл санаа, хүн чанар, ёс суртахуун, хүмүүсийн хоорондох харилцааны хүйтэмсэг жихүүн асуудлыг хөндөж, утга сэдвийн хувьд урадчуудын хот хөдөөгийн шинэ амьдрал, ёс суртахуун, хайр сэтгэл, хүн байгалийн харилцааны асуудал, хотжилт хийгээд хөдөө нутгийн нүүдэл соёл иргэншил хоёрын хоорондох зөрчил мөргөлдөөн, малчин ард хэрхэн идээшүүлэн авч байгаа байдал, хөдөө нутгийн ажил амьдрал, малчин монгол ахуйг тусган илрүүлж үүгээрээ дамжуулан урад нутгийн уул ус, хүн байгаль, нутаг гурвын амин холбоог тусгажээ. Энэ чанар нь түүний тууж, өгүүллэгийн туурвил зүйн үндэстний онцлогийг харуулж байна. Зохиолч тухайн нийгэм цаг үеэ тусгах, хүний сэтгэлийн нууцыг дэлгэн тоочихдоо уран дүрийг бүтээх, дүрслэх зохиомж өгүүлэмжийн аргыг ашиглажээ. Зохиолд дүрслэгдэж байгаа гол баатрын зан чанарын ялгарал, дотоод сэтгэлийн илрэл, зохиолын баатрын хувь заяа, уран дүрийн дотоод сэтгэл рүү гүнзгий нэвтрэх бичлэгийн арга туршлага бол М.Мөнхөөгийн уран дүрийг бүтээсэн чухал онцлог шинж юм.

# ДАМДИНСҮРЭНГИЙН УРИАНХАЙН ЯРУУ НАЙРГИЙН БҮТЭЭЛД ТУССАН УЛС ТӨР, ЭКОЛОГИЙН ҮЗЭЛ САНАА

*Доктор (Ph.D) Доржжигжидийн Мөнхнаран*

Зохиолч, яруу найрагч, гүн сэтгэгч Дамдинсүрэнгийн Урианхай нь зохиол бүтээлээрээ дамжуулан Монгол Улсад хөгжиж ирсэн ардчиллын алдаатай талыг сануулж, улс төрчдийн алсын хараагүй, амин хувийн ашиг харсан бурангуй байдлыг шүүмжилж ирсэн билээ. Зохиолчийн хувьд уран бүтээлийнхээ эхэн үед соёл иргэншлийг дэмжин, технологийн дэвшлийг магтан дуулж (”Би-дотоод шаталтын хөдөлгүүр” найраглал, 1974, “Хүн танаа” яруу найргийн анхны түүвэр, 1972 зэрэг) байсан бол уран бүтээлийн 2-р үеэс (1990-2000 он) эхлэн соёл иргэншлийн нөлөө байгаль орчинд төдийгүй хүний мөн чанарт хүртэл сөргөөр нөлөөлж байгаад сэтгэл эмзэглэн бичих болсон билээ. Тус өгүүлэлд Д.Урианхайн яруу найргийн бүтээлд байгаль эхийг хүндлэн дээдлэх үзэл нь хэрхэн туссан болох, соёл иргэншлийн нөлөөгөөр байгаль эх сүйдэж, хүний мөн чанар “хүйтэрч” байгаад сэтгэл эмзэглэн бичсэн экологийн үзэл санааг, мөн ардчилсан хувьсгалаас хойших жилүүдийн улс төрийн байдал, улс төрчдийн увайгүй үйлдэл, үнэн төрхийг шүүмжилсэн үзэл санааг нь тус тус задлан тайлбарлаж байна.

# “ИХ МОНГОЛЫН ОРНЫ ЭРТНИЙ ТҮҮХИЙН ТЭМДЭГЛЭЛ ШАСТИРЫН ӨНЦГИЙН ЧИМЭГТ МОНГОЛ ҮСГЭЭС ТӨВӨД ХЭЛЭНД ОРЧУУЛАН ЗОХИОСОН ОРШИВ” ХЭМЭЭХ ТҮҮХЭН СУРВАЛЖИЙН ТУХАЙ

*Хомоолын Түмэнбаяр*
*(Соёлын өвийн үндэсний төв)*

Төвөд хэлээр бичсэн түүхийн зохиолын дотор хэмжээгээр бага боловч хэл найруулга, зохиомж, агуулгаараа нэлээд өвөрмөц зохиолын нэг бол “Гайхамшигт алтан дэвтэр”-ийн хавсралт" юм. Энэ түүхэн сурвалж XX зууны эхэнд уламжлалт нийгмийн байгуулал солигдож шарын шашин бараг хаагдах үед зохиогдсон төвөд хэл дээр бичигдсэн хамгийн сүүлчийн эх сурвалж болно. Зохиогчийн дэвшүүлсэн зохиолын үндсэн агуулга, гол сэдвийн хүрээнд, өмнө өөрийн бичсэн “Гайхамшигт Алтан дэвтэр” бүтээлд ороогүй зүйлүүдийг өөрийн тодорхой байр сууриар нэмэлт хавсралт болгосон нь сонирхолтой юм. Гэвч нэмж дэлгэрүүлсэн төдий бус, бас Монголын түүхийн талаар шинэ баримтад тулгуурлан хандсан нь үндсэн эх зохиол, түүний хавсралт болгож хийсэн эл зохиол хоёрыг харьцуулан үзэхэд тодорхой байна. Энэ бүтээл нь монголчуудын төвөд хэлээр бичиж байсан их, бага ухааны арван орны арвин их бүтээлийн доторх, түүх, нийгэм, улс төрийн шинэлэг сэтгэлгээгээр бичсэн, сүүл үеийн чухал ховор дурсгал болж буйгаараа, монголчуудын мэдлэг ухаан, оюун сэтгэлгээний түүхийг нэмэн тодруулахад, улмаар нарийвчлан үзвээс зохих чухал сурвалж болно.

# “ЦАГИЙН ЖАМЫГ ТОДРУУЛАГЧ ЦААСАН ШУВУУ” ЗОХИОЛЫН АНХНЫ ХЭВЛЭЛҮҮД

*Дашнямын Мөнх-Отгон*
*(ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн)*

Өнгөрсөн зууны эхээр Монголын Нийслэл хүрээнээ хорголжин үсгийн өрмөл монгол бичгийн ном дэвтэр хэвлэж эхлэх үест ард олонд үлэмж нөлөөтэй болсон Ноён хутагт Данзанравжаагийн хамгийн алдартай сургаалын шүлэг зохиолуудаас эн түрүүнд хэвлэсэн бололтой. Үүнд манай алдарт “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу хэмээгч нэрт судар оршвой” зохиолыг лавтай гурван удаа, мөн “Ноён гэгээнтний зохиосон хаврын өдрийн зугаа хэмээгдэх оршвой”, “Мэргэн ноён хутагтны зохиосон сургаалын шастир оршвой” зэрэг зохиолуудыг ямар боловч нэг, нэг удаа хэвлэсэн байна. Гурван зохиол нь уламжлалт босоо нарийн бийрийн бичмэл дэвтрийн хэлбэртэй муутуу цаасан дээр, гарчгийг хоёр мөр зэрэгцүүлэн толгойг чацуулж том үсгээр хэвлэсэн байдал зэргээс үзэхэд нэгэн хамт дармалласан нь тодорхой.

Академич Ц.Дамдинсүрэн “Монгол уран зохиолын дээж зуун билиг” номдоо “Ноён хутагт Равжаагийн зохиосон Цаасан шувуу” зохиолыг бяцхан тайлбарын хамт хэвлүүлэхдээ энэ зохиол нь XX зууны эхээр монголын Нийслэл хүрээнд хоёр удаа хэвлэгдсэн бөгөөд хэвлэгдэхээс урьд ч бичмэлээр ихэд тархсан байв” хэмээн бичиж байсан боловч үүнээс хойш бид өөр нэгэн хэвлэлийг нэмж тодруулав. Чингээд бид нийт гурван ондоо хорголжин барын эх бичигтэй болоод байгаа билээ.

# ЦАХИМ СҮЛЖЭЭ ДЭХ ЯРУУ НАЙРГИЙН УЛАМЖЛАН ДАМЖИХ ҮЙЛ ЯВЦЫГ ШИНЖЛЭХ НЬ

*Анхилам*
*(ӨМБИС-ийн Монгол судлалын дээд сургууль)*

Интернэт түргэн хөгжилтийг дагалдан, сүлжээний уран зохиол уран зохиолын чухал нэгэн үзэгдэл болсон ажээ. Монгол уран зохиолын хүрээнд интернэт мэдээллийн мэндэлсэн нь бусад уламжлалт мэдээллийн хэрэгслээс ялгагдах шинэ уламжилгын тавцанг хангаж, шинэ амилал олгосон билээ. Интернэт мэргэжлийн хэрэглээний хүрээ ихсэхийг дагалдан монгол уран зохиол голдуу уламжлалт мэдээллийн хэрэгсэл болон интернэт мэдээллийн хэрэгслээр харилцан улиран уламжлагдах болж, түүний орших хэлбэр хийгээд үргэлжлэх хэлбэр ч дагалдан баяжжээ. Иймээс зуучийн хувиралтаас болсон тэмдгийн оршихуйн хэлбэрийн өөрчлөлт нь сүлжээгээр ачаалагч болгосон уран зохиолын уламжилгын бүх гогцоон дахь хувиралтын хандлагыг бий болгосон нь анхаарууштай. Шинэ зуунд Өвөр Монгол уран зохиол нь голдуу “Хятад улсын монгол хэлний сонин мэдээ”, “Холбоо”, “Алтан хүрд”, “Монгол гэр”, “Дуран хараа” зэрэг сүлжээн өртөө буюу “Шинч баян”, “Тор 49”, “Зөөлөн хур” зэрэг Wechat олон нийтийн тавцан хийгээд “Байна уу” зэрэг интернэт мэдээллийн хэрэгслээр ачаалагч болгон уламжлах явцдаа бусад уламжлалт мэдээллийн зуучлагч хэрэгслийг уусгасан буюу өөрийн өвөрмөц хэлбэрээр орших болсон. Ийнхүү тус өгүүлэлд уламжилгын зуучийн хувиралтаас болсон сүлжээний монгол хэлний яруу найргийн уламжлагчийн төрөл цогц, тэмдэг болох сүлжээний яруу найраг хийгээд хүлээн авагч зэргийн онцлогийн тухай товч өгүүлэхийг хичээжээ.

# ӨВӨР МОНГОЛЫН БИЕ МАХБОДЫН ГОО ЗҮЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

**(Өвөр Монголын одоо үеийн уран зохиолын жишээгээр)**

*Урьхан*
*(ӨМБИС-ийн Монгол судлалын дээд сургууль)*

Бие махбод бол хамгийн түрүүнд соёлын тэмдэг, мэдлэгийн хэлбэр. Бие махбодын гоо зүйн (soma aesthetics) тухай ойлголтыг Америкийн эрдэмтэн Ричард Шустер Richard Shusterman 1999 онд санал болгов. Тэрээр бие махбодын гоо зүйг гурван онолын ангилалд хуваадаг: analytical soma aesthetics, pragmatism soma aesthetics, pragmatism soma aesthetics.

Хятадын эрдэмтэд эртний Хятадын философи, хэрэглээний салбар, утга зохиолын шүүмж зэрэг хэдэн салбараас биеийн гоо зүйг судалжээ. Харин Өвөр Монголын эрдэмтэд хараахан судалсан зүйл үгүй байсаар.

Тус өгүүлэлд байгалийн гоо зүй, нийгмийн бие махбодын судлал, хүйсийн судлал зэрэг гурван талаас хураангуйлан, хятад судлаачдын бие махбодын гоо зүйн талаарх судалгааны сэтгэхүй санааг танилцуулах бөгөөд бас энэ чиглэлээр хүндэт эрдэмтэдтэй санал солилцох сонирхолтой байна.

# СТАНДАРТЧИЛСАН НЭР ТОМЬЁОНЫ БҮТЦЭД ХИЙСЭН ТООН ШИНЖИЛГЭЭ

*Түвдэндоржийн Батбямба*
*(ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн)*

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарт хэрэгжүүлж буй “Монгол нэр томьёоны стандартын судалгаа (Нэр томьёог боловсруулах арга, зарчмын олон улсын стандартыг нутагшуулах)” суурь судалгааны төслийн хүрээнд Монгол Улсад ашиглаж буй 10387 стандартчилагдсан нэр томьёоны сан бүрдүүлэв. Бидний цуглуулсан сан дахь 10387 нэр томьёо нь 1-13 үгээс бүтсэн байна. Стандартчилагдсан нэр томьёоны бүтцийг судлах нь нэр томьёо товч тодорхой, салаа утгагүй бөгөөд оновчтой байх гэсэн нэр томьёоны үндсэн шаардлагад нийцэж буй эсэхийг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Иймд уг судалгаа, ажиглалтдаа тулгуурлан стандартчилагдсан нэр томьёоны бүтцийн талаар өөрсдийн саналаа нэмэрлэхийг зорив.

# МАХГАЛЫН ГЭРЭЛТ ХӨШӨӨНИЙ МАНЖ БИЧЭЭСИЙН ҮГИЙН САН, ҮСЭГ ЗҮЙН ОНЦЛОГООС

*Эрдэнэбилэгийн Эрдэнэзуу (ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн)*
*Батболдын Ганчимэг (Чингис хааны өв, соёлын хүрээлэн)*

Өгүүлэн буй дурсгал нь Манжийн Дээд эрдэмтийн гуравдугаар он (Wesihun erdemungge-i ilači aniya 1638 )-д холбогдох нийт 25 мөрөөс бүрдэх Махгалын мэдээг агуулсан чухаг дурсгал юм. Мүгдэний Махгал шүтээний тухай “Дайчин улсын тулгар төр нээсэн бодлогын бичиг” хэмээх манж сурвалжид мөн товч мэдээ бий. Тэр мэдээг үгчлэн орчуулбаас: (ma: yuwan gurun-i sizu han i fonde. pakesba lama. minggan yan aisin-be gur mahag'ala hunggerefi. u tai šan alin-de jugtehe: amala monggoi sasgiya bade gamafi juktehe. jai sereb kūtuktu lama solifi. cahar gurun de gamafi juktembihe. ede isinjifi. mergen lama. taizung hūwangdi i erdemu horon goro selgiyebufi. geren gurun be dahabufi. turun kiru be wasihūn forobure jakade. cahar han alime gaihakū burulaha. abkai forgon musei gurun de oho be safi. fucihi be gajime dahame jihe (Stratégia 1786: 19. kötet, 60a). “Юань гүрний Шизү хааны үед Пагба лам мянган лан алтаар Гүр Махгал цутгаж, У тай шань ууланд тахив. Хойно Сажа газарт аваачиж тахив. Сарба хутагт лам залж, Цахар улсад аваачин тахиж бүлгээ. Үүнд хүрч ирээд, Мэргэн лам Тайзун хуандийн эрдэм цог хол тархаж олон улсыг дагуулж, туг хиурыг баруунш хандуулах тулд Цахар хаан хүлээж эс аваад буруулав. Тэнгэрийн бошго бидний улсад болсныг мэдээд бурхныг авчирч дагаж ирвэй” гэжээ. Энэ мэдээ угтаа “Дайчин улсын магад хууль”-д байдгийг хожим “Бодлогын бичиг”-т бас оруулсан байна. Энэ гэрэлт хөшөөний бичээс бол манж төдийгүй монголын түүхэнд илүү холбогдох чухал дурсгал гэж болно. Хубилай хааны үед Сажын дээдэс, улсын багш Пагба лам 1000 лан алтаар Гүр Махгал бурхныг цутгуулж, Их Юань улсын төрийн шүтээн болгон тахиж, У тай шань ууланд залж байжээ. Гүр Махгал нь Юань улсыг элдэв аюул хөнөөлөөс аврагч улсын их шүтээн болж байв. Хожим Сажын хийдэд аваачиж залсан ба Лигдэн

хааны үед Сажын тэргүүн Сарва хутагт лам Цахарт авчирснаар дахин тэр үеийн Монголын төрийн шүтээн болжээ. Лигдэн хутагт хаанд төрийн гурван их шүтээн байлаа гэдэг нь Алтан Ганжуур, төрийн хасбуу тамга, Гүр Махгал бурхан эдгээр болно. 1634 онд Доргон ноёноор удирдуулсан Манжийн их цэрэг Цахарыг дайлахуйд Цахарын Мэргэн лам уг бурхныг авч Манжид дагаж орсон байна. Хөшөөний бичээсээс үзвэл, манж нар Махгал бурхныг Манжийн төрийн шүтээний зэрэгт хүндлэн тахиж, тусгайлан тахилын сүм байгуулсан ажээ. Энэ бол Чин улсын харьяанд олон монголчууд дагаж орсон, нөгөөтээгүүр энэ Махгал бурхан монголчуудын уламжлалт эрхэм шүтээнд тооцогдож байсантай холбоотой юм. Тахилын сүмийг байгуулсан Мүгдэн хот нь тухайн үедээ Манж улсын нийслэл байв. Чингээд Чин улсын оршин тогтносон гурван зуу гаран жилийн туршид манж монголчуудын тасралтгүй тахиж шүтэж байсан шүтээн нь олны дунд Мүгдэн Махгал хэмээн алдаршсан билээ.

Бид энэхүү өгүүлэлдээ Мүгдэн дэх Махгалын гэрэлт хөшөөний манж бичээсийн үгийн сан, үсэг зүйн онцлог, тухайлан манж бичээст орсон самгарди, төвөд, хятад, уйгур, монгол үгсийн талаар өгүүлэхийг зорилоо.

# МОНГОЛ УЛСЫН “ҮНЭН”, ӨМӨЗО-Ы “ӨВӨР МОНГОЛЫН ӨДРИЙН СОНИН” (1950-1960 ОН) СОНИНЫ ХЭЛ НАЙРУУЛГАД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

*Амар*
*(МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль)*

Тус өгүүлэлд Монгол Улсын “Үнэн”, БНХАУ-ын ӨМӨЗО-ы “Өвөр Монголын өдрийн сонин” сонины 1950-1960 оны дугаарт нийтлэгдсэн сурвалжлагын төрлийг сонгон сонины хэл, найруулгын талаас зарим ажиглалт хийж, үр дүнгээсээ танилцуулсан байна. Эх хэрэглэгдэхүүнийг сонгохдоо сэтгүүл зүйн "Орон зай цаг хугацааны явцуу хүрээнд болж буй үйл явдал, үзэгдэлд зохиогч өөрөө оролцож, гэрч болсны үндсэн дээр түүнийг хөгжил, хөдөлгөөн, өөрчлөлт дунд нь харуулж, тухайн цаг мөчийн мэдрэмж, онцлог шинжийг нүдэнд үзэгдэж, сэтгэлд буутал дүрслэн мэдээлдэг мэдээллийн бичлэгийн төрлийн шуурхай зүйл…" болсон сурвалжлага гэх төрөлд бүрэн дүйцэх тухайн цаг мөчийг тод томруун буулгасан зэрэг олон хэмжүүрээр сонгон авахыг хичээсэн болно.

Бидний зорилго бол нэгд, сурвалжлагуудын хэл найруулгын өвөрмөц онцлогийг зэрэгцүүлэн авч үзэх, хоёрт, тэдгээр сурвалжлагад агуулагдаж байгаа танин мэдэхүйн ач холбогдолтой зарим мэдээ баримтыг өнөөгийн өндөрлөгөөс эргэн нягтлахад оршино.

# “DEDE KORKUT KITABI” ХЭМЭЭХ СУРВАЛЖИЙН ТУХАЙ

*Өргөнбуян*
*(МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль)*

Орхон голын хөндий Хар балгасанд нийслэллэн байсан Уйгурын хаант улс 840 онд мөхөхөд зарим ноёд язгууртнууд нь Киргизийн ноёрхлыг эс тэвчин өрнө зүг нүүдэллэж, Шинжаан оронд Уйгурын төр улсыг дахин байгуулж, улс гүрэн нь хөгжин бадарч байсан хэдий ч зарим овог аймгийнх нь ноёд үл суурьшин өрнөшөө нүүдэллэж, Дундад Азийн Амударьяа, Сырдарьяа мөрний сав газар хүрээд, Хар ханы хаант улсыг(840–1212) байгуулж, мөн тэндээ Огуз, Кипчакийн холбоог бий болгон Кавказын нуруу хүртэлх өргөн уудам газар нутгийг захирч байв. Энэхүү түүхэн цаг үед “Dede Korkut Kitabi” хэмээх туульс зохиогдож өргөн хүрээнд амаас ам дамжин уламжлагдан тархсан байдаг. Төв Азийн нүүдэлчин удмын Уйгур-Огуз нарын дунд анх амаар уламжлан хайлж байсан эл туульс нь хожим Дундад Азийн ард түмний утга соёлын охь шимийг шингээн сүлэлдсэн бөгөөд XIII-XV зууны хооронд хайлах агуулга ба хүүрнэх хэлбэр нь аажмаар тогтворжин XVI зуун болоход хоёр сонгодог гар бичмэл бий болон бичгийн хэлнээ буусан байна.

“Dede Korkut Kitabi” тууль нь эртний түрэг хэлт ард түмний түүх, аж амьдрал, үйлдвэрлэл, зан заншил, шүтлэг бишрэл, шүлэг дууллын урлагийг тусгасан маш үнэ цэнтэй утга зохиолын бүтээл болох юм. Энэхүү өгүүлэлдээ “Dede Korkut Kitabi” хэмээх туульсын зохиолын бий болсон түүхэн цаг, агуулга, хэлбэр, мотиф болон хэв шинжийн онцлог, үйл явдал тэргүүтнийг нарийвчлан авч үзсэн болно.

Тэмдэглэл

Тэмдэглэл

Тэмдэглэл